

# ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.02.10



## Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

### ТОВЧ

- Богд банк ХК хаалттай хувьцаат компани болохоор шийдвэрлэв.
- Монос Хүнс ХК-ийн ашиг 17% өсөв.
- Голомт банк ХК-ийн P/E харьцаа 2.47 байгаа нь хувьцааны ханш өсөх боломжтойг илтгэж байна.
- Төрийн өмчит компаниудын хувьцааны ханш оны эхнээс өсөлтөөрөө тэргүүлж байна.

### МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	0.51%	2.05%	25.47%
MSE A	0.87%	1.95%	20.27%
MSE B	-0.54%	3.99%	34.89%
2025/02/03 – 2025/02/07			

### Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
INV	2,328,419,100.00
NEH	1,640,800,872.90
GLMT	428,257,981.00
KHAN	399,910,884.00
MSE	298,644,848.13
2025/02/03 – 2025/02/07	

### Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
BOGD	142.00	33.97%
SOR	2,750.00	30.64%
MCH	949.98	18.75%
HBZ	6,900.00	15.00%
TAV	8,740.00	15.00%
2025/02/03 – 2025/02/07		

2025 он 02-р сарын 10

Зах зээлийн  
үнэлгээ тэрбум ₮

**13,286**

ТОП-20 индекс

**52,731**

MSE A

**20,383**

MSE B

**15,649**



### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

**5.0%**

2024-III улирал

Инфляц

**9.0%**

2024-12 сар

ГВУН(сая\$)

**5,509**

2024-12 сар

Бодлогын

хүү

**10.0%**

ЗГ-ын бондын  
өгөөж

**6.92%**

USD/MNT

**3,455.22**

2025-02-09



## Дотоодын зах зээлийн мэдээлэл

### БОГД БАНК ХК ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛОХООР ШИЙДВЭРЛЭВ



2025 оны 2-р сарын 9-нд Богд банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл хуралдаж, компанийн хэлбэрийг "Нээлттэй ХК"-иас "Хаалттай ХК" болгон өөрчлөх, шинэчилсэн дүрмийг батлах асуудлыг хэлэлцлээ.

Тус банкны удирдлагуудын мэдээлснээр, банкны тухай хуулийн дагуу хувьцаа эзэмшигчийн эзэмших хувь 20%-иас хэтрэхгүй байх зохицуулалттай байдаг ч, хоёрдогч зах зээл дээрх хувьцааны эргэлт болон хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал энэ зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байгаа юм. Иймээс, банкны удирдлага ийм шийдвэр гаргасан гэжээ.


Мөн, банкны удирдлагаас хувьцаа эзэмшигчдэд нэгж хувьцааг 150.0 төгрөгөөр эргүүлэн авах санал танилцуулжээ. 2025 оны 1-р сарын 8-ны өдрийн байдлаар бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчид энэхүү үнээр хувьцаагаа банканд буцаан худалдах боломжтой болсон юм.

### МОНГОЛ БАНК 2025 ОНЫ 1-Р САРД 1.2 ТОНН ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВЛАА



2025 оны 1-р сард Монголбанк 1,236.5 кг үнэт металл худалдан авчээ. Энэ нь оны эхнээс өссөн дүнгээр 1.2 тонн үнэт металл худалдан авсан дүн бөгөөд өмнөх оны мөн үеэс 21.9 хувиар өссөн үзүүлэлт юм. Мөн, Монголбанк нь бүс нутгуудаас үнэт металл худалдан авах ажлыг үргэлжлүүлсээр байна. Тухайлбал, Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 26.3 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны хэлтэс 175.8 кг үнэт металл тус тус худалдан авсан байна.

#### График 1. Алт, мөнгөний үнэ (₮/гр)



### ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН ХУВЬЦААНЫ ХАНШ ӨСӨЛТӨӨРӨӨ ТЭРГҮҮЛЖ БАЙНА

2025 он эхэлснээс хойш төрийн өмчит хувьцаат компаниудын хувьцааны ханшид томоохон өсөлт гарч байгаа нь Засгийн газраас хэрэгжүүлж буй нээлттэй, ил тод байдалд шилжүүлэх бодлогын үр дүн гэж үзэж болох юм. Тухайлбал, МСН, SHV, BAN компанийн хувьцаа тус тус 75.92%, 73.67%, 41.83%-иар өсөөд байна.

Энэхүү өсөлт нь эрчим хүчний үнийн нэмэгдэлтэй шууд холбоотой бөгөөд нүүрс олборлогч компаниуд нүүрсээ өндөр үнээр борлуулах боломжтой болж байгаа нь энэ өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйлүүдийн нэг болж байна.



## ТОП-20 индекст багтах компаниудын 2024 оны жилийн эцсийн тайлан

2024 оны шинэчилсэн ТОП-20 индексийн багцад өмнөхөөс 17 компани хэвээр үлдэж, харин "Сэндли ББСБ" ХК, "Монос хүнс" ХК, "Газар шим үйлдвэр" ХК хасагджээ. Тэдний оронд "Хас банк" ХК, "Ард санхүүгийн нэгдэл" ХК, "Лэндмн ББСБ" ХК шинээр багтан, индексийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороод байгаа билээ. Тэгвэл ТОП-20 индекст багтах компаниуд санхүүгийн аудитлагдаагүй тайлангаа танилцуулсаар байна.



### МОНОС ХҮНС ХК-Н АШИГ 17% ӨСЛӨӨ



2024 онд Монос Хүнс ХК нь MFC-2 үйлдвэрээ ашиглалтанд оруулж, хүчин чадлаа нэмэгдүүлсэн. Энэ нь компанийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж, үйл ажиллагааны өргөжилтөд чухал үүрэг гүйцэтгэж байна. Борлуулалтын орлого 38.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19.9%-иар өссөн. Цэвэр ашиг 4.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 17%-иар өссөн.

**График 2. Борлуулалтын орлого (тэрбум төгрөг)**

**График 3. Цэвэр ашиг (тэрбум төгрөг)**



Үзүүлэлтүүд	
P/E TTM	8.78
P/B	1.4
EPS	9.97 ₮
33Y	35.78 тэрбум ₮



### ГОЛОМТ БАНК ХК-Н 406.7 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ЦЭВЭР АШИГТАЙ АЖИЛЛАА



Голомт банк 2024 онд 406.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, өмнөх оноос 124.9%-иар өссөн байна. Үнэ ашгийн харьцаа банкны салбарын дунджаас доогуур буюу 2.47 байгаа нь хувьцааны өсөлтийн боломж байгааг илтгэж байна. Голомт банкны зээлийн багц 2024 онд огцом өсөж 7.2 их наяд хүрсэн бөгөөд энэ нь өмнөх жилтэй харьцуулахад 57.8%-ийн өсөж, сүүлийн 3 жилд нийт актив жилд дунджаар 25% өссөн үзүүлэлтэй байна.

**График 4. Цэвэр ашиг (тэрбум төгрөг)**

**График 5. P/E харьцаа**



- Нийт активын хэмжээ – 15.4 их наяд (Жилийн өсөлт: 34.4%)
- Харилцагчдаас татсан эх үүсвэр – 8.5 их наяд
- Хүүгийн орлого – 1.2 их наяд (Жилийн өсөлт: 35.1%)
- Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS) – 502.9 (2023 онд 223.6)
- Хувьцааны ханш – 2024 онд 36.5% өсөв



## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН СОНГОЛТ ХЭРХЭН ХИЙХ ВЭ?

График 6. МХБ-ын ТОП-20 индекст багтах компаниудын ногдол ашгийн өгөөж (2024Y2)





График 7. МХБ-ын ТОП-20 индекст багтах компаниудын үнэлгээний матриц (2024Y2)



\*Үнэ-ашгийн харьцаа (P/E) нь компанийн үнэлгээ зах зээлийн хүлээлттэй хэр нийцэж байгааг харуулдаг бол ногдол ашгийн өгөөж (DY) нь хөрөнгө оруулагчдад шууд орлогын эх үүсвэр болдог. Иймд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа P/E болон DY-ийн тэнцвэрийг харгалзан үзэх нь зах зээлийн эрсдэлийг удирдаж, өгөөжийг оновчтой болгоход чухал ач холбогдолтой.